

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН БАТАЛСАН
ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

1. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго:

Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх зарим арга хэмжээний тухай” 206 дугаар тогтоол, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 1/1263 дугаар албан бичгийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг тооцох, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад оршино.

2. Арга зүй, ашигласан эх сурвалж:

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу улсын нэгдсэн санд бүртгэлтэй Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актуудын хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээлэл, Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлтэд үндэслэн хийв.

3.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрийн ерөнхий мэдээлэл

3.1. Засгийн газрын 2025 оны “Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх зарим арга хэмжээний тухай” 206 дугаар тогтоол, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 1/1263 дугаар албан бичгийн дагуу дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/88 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, зааварт дүн шинжилгээ хийж Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэх, хүчингүй болгох, өөрчлөх, холбогдох зохицуулалтыг хуульд тусгах, санал боловсржуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллав.
- Засгийн газрын 2025 оны “Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх зарим арга хэмжээний тухай” 206 дугаар тогтоол, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 1/1263 дугаар албан бичгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2026 оны 02/798 дүгээр албан бичгээр нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний акттай холбоотой санал хүсэлтийг хүлээн авч ажиллав.

3.2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй нийт 7 шийдвэр байна.

Батлагдсан шийдвэрийг харуулбал:

№	Шийдвэрийн батлагдсан огноо	Шийдвэрийн нэр	Заавар, журмын утга	Захиргааны хэм хэмжээний акт улсын нэгдсэн санд бүртгээгдсэн эсэх	
				Огноо	Дугаар
1	2023.10.24 A/139	Журам батлах тухай	Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам;	2023.12.28	6519
2	2023.12.27 A/190	Журам батлах тухай	Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам;	2024.02.16	6641
3	2023.12.28 A/194	Журам батлах тухай	“Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”-ыг нэгдүгээр, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”-ыг хоёрдугаар, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг гуравдугаар, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”-ыг дөрөвдүгээр, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг тавдугаар, “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”- ыг зургаадугаар, Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг долоодугаар, “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн өргөдлийн маягт”-ыг наймдугаар хавсралтаар;	2024.02.16	6642
4	2024.06.18 A/107	Журам батлах тухай	Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам;	2024.07.08	6885
5	2024.12.26 A/246	Журам, заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай	Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам”-ыг нэгдүгээр, “Тэтгэвэр бодох заавар”-ыг хоёрдугаар, “Өндөр насны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар”-ыг гуравдугаар, “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар”-ыг дөрөвдүгээр, “Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар”-ыг тавдугаар, “Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох маягтын загвар”-ыг зургаадугаар хавсралтаар;	2025.01.06	7020

6	2025.10.10 A/267	Заавар батлах тухай	Тэтгэмж бодох заавар	2025.11.04	7399
7	2025.11.03 A/298	Журам батлах тухай	Нийгмийн даатгалын хяналт шалалтын нэгдсэн журам	2025.12.05	7433

4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хийх хяналт-шинжилгээний чиглэл:

Тус шинжилгээг дараах 2 чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд:

4.1. Дараах чиглэлийн дагуу судалгаа гаргах;

- Хуулиар тусгайлан эрх олгосны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний акт;
- Хуулиар эрх олгосон боловч батлаагүй захиргааны хэм хэмжээний акт;
- Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй боловч нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан хэм хэмжээ тогтоосон шийдвэр;

Дээрх судалгааг гаргахад хуулиар эрх олгосон боловч батлаагүй болон хуулиар тусгайлан эрх олгогдоогүй боловч нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан хэм хэмжээ тогтоосон шийдвэр байхгүй байна. Харин Хуулиар тусгайлан эрх олгосны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний 1 акт байна.

4.2. Дээрх судалгаанд үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу хийв. Үүнд:

- Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох;
- Эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох;
- Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх;
- Хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасны үндсэн дээр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;
- Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар тусгайлан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх
- Хавсралтаар баталсан журмын доторх эшлэл хийсэн хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэхийг нягталж, өөрчлөлт орсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийлгэх.

4.2.1. Хүчингүй болгох захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх;

Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлал, мөн эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон захиргааны хэм хэмжээний акт, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх захиргааны хэм хэмжээний акт байхгүй байна.

4.2.2.Хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;

Хяналт-шинжилгээгээр улсын нэгдсэн санд бүртгүүлэх шаардлагатай захиргааны хэм хэмжээний акт байхгүй байна.

4.2.3. Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар тусгайлан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх

Нийгмийн даатгалын ерөнхий газрын баталсан 7 захиргааны хэм хэмжээний актын үндэслэл болгосон хуулийн заалтыг тус бүрээр нь үзэхэд тухайн үндэслэл болгосон хуулийн заалт одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ба тусгайлан эрх олгосон хуулийн заалт ба хүчингүй болсон, хууль нь бүхэлдээ шинэчлэн батлагдсан зүйл байхгүй байна.

Үндэслэл болгосон хуулийн заалтыг журам тус бүрээр харуулбал:

№	Баталсан захиргааны байгууллага, огноо дугаар	Актын нэр	Заавар, журмын утга	Үндэслэл болгосон хуулийн заалт
1	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/139 дүгээр тушаал;	Журам батлах тухай	Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам;	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" А/136 дугаар тушаал;
2	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/190 дүгээр тушаал;	Журам батлах тухай	Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг;

			журам;	
3	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/194 дүгээр тушаал;	Журам батлах тухай	Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам;	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг;
4	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/107 дугаар тушаал;	Журам батлах тухай	Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам;	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалт;
5	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/246 дугаар тушаал;	Журам, заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай	Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам;	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг;
6	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/267 дугаар тушаал;	Заавар батлах тухай	Тэтгэмж бодох заавар	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг;
7	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дугаар сарын 03-ны өдрийн А/298 дугаар тушаал;	Журам батлах тухай	Нийгмийн даатгалын хяналт шалалтын нэгдсэн журам	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1, 37.14.7 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.2, 38.9 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан, "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 3.4 дэх заалт

4.2.4.Хавсралтаар баталсан журмын доторх эшлэл хийсэн хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэхийг нягталж, өөрчлөлт орсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийлгэх;

Дээрх 7 заавар, журмын хавсралтаар баталсан журмын доторх эшлэл хийсэн хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэхийг нягтлахад өөрчлөлт ороогүй, доторх үндэслэл болгосон заалтууд нь хүчинтэй хэвээр, холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна.

5. Үр дүн:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан дээрх 7 захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явцыг 100 хувь буюу холбогдох шийдвэр нь биелэлт бүрэн хангагдсан буюу “Бүрэн хэрэгжсэн” гэж үнэлэгдсэн. (Хэрэгжилтийг хавсралтаар харуулав.)

Шийдвэрийг харуулбал:

№	Эрх зүйн баримт бичиг	Үнэлгээ хувь
1	Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам;	100
2	Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам;	100
3	Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам;	100
4	Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам;	100
5	Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам;	100
6	Тэтгэмж бодох заавар	100
7	Нийгмийн даатгалын хяналт шалалтын нэгдсэн журам	100
Хэрэгжилтийн дундаж хувь		100

6.Дүгнэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актууд нь хууль тогтоомжид нийцсэн, эрх зүйн үндэслэлтэй, хуулиар эрх олгосон боловч батлаагүй, мөн хуулиар тусгайлан эрх олгогдоогүй боловч нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан хэм хэмжээ тогтоосон шийдвэр илрээгүй болно.

Түүнчлэн эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдсан, хууль тогтоомжтой зөрчилдсөн, хүний эрх, эрх чөлөөг хэт хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил болон авлигын эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлсэн зохицуулалт бүхий захиргааны хэм хэмжээний акт, мөн хуулиар тусгайлан эрх олгосон заалтад өөрчлөлт ороогүй бөгөөд хуульд заасны дагуу баталсан боловч улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний акт байхгүй байна.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актуудын бүртгэл, нэгдсэн санд бүртгүүлэх, өөрчлөлт, хөдөлгөөнийг цаг тухайд нь хийх ажил цаг хугацаанд нь шуурхай хийгддэг, эрх зүйн байдал, хэрэгжилт хэвийн түвшинд байна гэж дүгнэв.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 7 шийдвэр нь иргэд, даатгуулагч, ажил олгогчид чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа шийдвэрүүд бөгөөд биелэлтийн хувь “Бүрэн хангалттай” буюу 100 хувийн хэрэгжилттэй байна.

7. Цаашид авах арга хэмжээний санал

- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, тушаал, зөвлөмжийг захиргааны хэм хэмжээний актын бүртгэл, нэгдсэн санд бүртгүүлэх, өөрчлөлт, хөдөлгөөнийг цаг тухайд нь хийх;
- Нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох захиргааны хэм хэмжээний шийдвэрийг

хуулийн хэлтэст бүртгүүлж, хэвших;

- Захиргааны хэм хэмжээний актын үндэслэл болсон хуулийн заалт хүчингүй болсон, эсхүл хууль нь бүхэлдээ шинэчлэн батлагдсан тохиолдолд өөрчлөлтийг оруулж, уг хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгүүлэх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн тайланг хавсаргав.

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР